

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД,  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН  
ХАМТАРСАН ТУШААЛ

2022 оны 08 сарын 10 өдөр

Дугаар А/281, А/210

Улаанбаатар хот

Эрх олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Технологи дамжуулах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалт, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2021 оны А/381/А/274/А-313 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам”-ын 3.1 дэх хэсэг, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2022 оны А-06/А-05 дугаар хамтарсан тушаалаар байгуулагдсан хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох, цуцлахад зөвлөмж, санал, дүгнэлт гаргах, хяналт тавих чиг үүрэг бүхий орон тооны бус Зөвлөлийн хурлын 2022 оны ХТ2022/01 дүгээр шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эрдэнэс үндэсний судалгаа хөгжлийн төв” ХХК-д хүнд үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх эрхийг 3 жилийн хугацаатай олгосугай.

2. Хүнд болон хөнгөн үйлдвэрлэлийн технологийн түвшний үнэлгээ хийх байгууллагад эрх олгох журам” холбогдох хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулахыг “Эрдэнэс үндэсний судалгаа, хөгжлийн төв ХХК-ийн гүйцэтгэх захирал Б.Чинзоригт даалгасугай.

3. Тушаалын хяналт тавьж ажиллахыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нарт тус тус даалгасугай.

БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ  
УХААНЫ САЙД



Л.ЭНХ-АМГАЛАН

УУЛ УУРХАЙ, ХҮНД  
ҮЙЛДВЭРИЙН САЙД



Г.ЁНДОН